

Асуулгын хуудас боловсруулахад анхаарах зарим асуудлууд

МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн судлаач Б.Нарантулга

Нийгмийн үзэгдэл үйл явцын зүй тогтол, хувирал өөрчлөлт, хөгжил хөдөлгөөнийг танин мэдэх, тайлбарлах, хэмжих нэг арга бол нийгмийн судалгаа байдаг. Судалгааны мэдээллийг цуглуулахад хамгийн түгээмэл хэрэглэгддэг техник бол асуулгын хуудас юм.

Асуулгын хуудас нь харьцангуй хямд өртгөөр, хурдан хугацаанд, өргөн хүрээний мэдээллийг цуглуулах боломжтой, нөгөөтэйгүүр цуглуулсан мэдээллийг боловсруулахад хялбар байдаг нь энэ аргын давуу тал гэж үнэлдэг. Харин нэмэлт мэдээлэл цуглуулах боломжгүй, мөн хариулагчийн хандлагаас ихээхэн хамааралтай байдаг нь энэ аргын сул тал юм. Асуултыг агуулгаас нь хамааруулан төлөв байдлын болон хандлагын гэж ангилна.

Асуулгын хуудасны мөн чанар нь судалгааны зорилгод нийцсэн, үнэн зөв, бодитой мэдээллийг цуглуулахад оршино. Иймээс бид асуулгын хуудсыг боловсруулахдаа асуултуудын үг хэллэг, утга найруулгын талаар төдийгүй судалгааны бүрэн загварын талаар бодолцох ёстой.

Нэгэнт боловсруулагдсан асуулгын хуудсыг сайжруулахад хэрэглэгддэг арга техник нь туршилт байдаг. Туршилт нь асуултыг хэрхэн тавьбал хариулагчид илүү ойлгомжтой байхыг тодорхойлох; асуултуудад аль болох бүрэн хариулт авах боломжийг илрүүлэх; олон сонголттой асуултуудыг н хариултыг зөв байрлуулах; асуултуудыг логик дараалалд оруулах; асуулгыг бүрэн дуусгахад хэдий хугацаа шаардлагатайг тодорхойлох; ярилцлага авагч хэдэн насны, ямар хүйсийн хүн байвал илүү тохиромжтойг тогтоох зэрэг ач холбогдолтой.

1. Удиртгал

Нийгмийн үзэгдэл үйл явцын зүй тогтол, хувирал өөрчлөлт, хөгжил хөдөлгөөнийг танин мэдэх, тайлбарлах, хэмжих нэг арга бол судалгаа байдаг. Судалгааны мэдээллийг цуглуулахад хамгийн түгээмэл хэрэглэгддэг техник бол асуулгын хуудас юм. Нэлээд олон тооны хариулагчдыг хамарч, голдуу шинжилгээ хийх ба олон тооны үзүүлэлтүүдийн шинж байдал, хандлага, хамаарлын хэв маягийг тодорхойлох стратегийг баримталж буй судалгааны хувьд, өөрөөр хэлбэл тоон судалгааны хувьд асуулгын хуудсаар мэдээлэл цуглуулах нь хамгийн тохиромжтой.

Асуулгын хуудас нь мэдээлэл цуглуулалтын дараахь хэлбэрүүдэд ашиглагдана. Үүнд:

- Стандартлагдсан, албан ёсны ярилцлага

Энэ тохиолдолд ярилцлага авагч хариулагчтай нүүр тулж ярилцан, урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудасны хүрээнд холбогдох мэдээллийг авдаг бөгөөд энэ нь мэдээлэл цуглуулах хамгийн үр дүнтэй арга гэж тооцогддог.

- Шуудангаар мэдээлэл цуглуулах арга

Урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсыг шуудангаар илгээж, хариулагчаар бөглүүлэн мэдээлэл авах арга техник юм.

- *Ярилцлага авагчийн оролцоогүйгээр нэг хариулагчаас мэдээлэл цуглуулах арга*
Ярилцлага авагч хариулагч бүрт асуулгын хуудсыг тараан өгч, тэднээс холбогдох мэдээллийг авахыг хэлнэ. Албан ёсны ярилцлагаас ялгаатай тал нь ярилцлага авагч мэдээлэл цуглуулах үйл явцад бараг оролцдоггүй, шаардлагатай тохиолдолд хариулагчдад нэмэлт тайлбар өгнө.

- *Ярилцлага авагчийн оролцоогүйгээр бүлэг хариулагчаас мэдээлэл цуглуулах арга*
Энэ нь асуулгын хуудсыг хэсэг бүлгээрээ нийлж бөглөх арга юм. Бүлэг хариулагчаас мэдээлэл цуглуулах арга техник тэр болгон хэрэглэгддэггүй.


Асуулгын хуудас нь харьцангуй хямд өртгөөр, хурдан хугацаанд, өргөн хүрээний мэдээллийг цуглуулах боломжтой, нөгөөтэйгүүр цуглуулсан мэдээллийг боловсруулахад хялбар байдаг нь энэ аргын **давуутай тал** гэж үнэлдэг. Харин нэмэлт мэдээлэл цуглуулах боломжгүй, мөн хариулагчийн хандлагаас ихээхэн хамааралтай байдаг нь энэ аргын **сул тал** юм. Өөрөөр хэлбэл, хариулагч тухайн асуултыг ойлгосон эсэх, асуулгын хуудсанд хариуцлагатай, үнэн сэтгэлээсээ хандсан эсэх нь цуглуулсан мэдээллийн бодит байдалд ихээхэн нөлөө үзүүлнэ.

2. Асуулгын хуудас боловсруулах

Асуулгын хуудас нь тодорхой агуулга, зорилго, бүтэц, зохион байгуулалт бүхий асуулт, хариултуудын бүлгээс бүрдэж буй мэдээллийг цуглуулах, хэмжих шинжлэх ухааны арга хэрэгсэл юм. Түүний мөн чанар нь судалгааны зорилгод нийцсэн, үнэн зөв, бодитой *мэдээллийг цуглуулахад* оршино. Иймээс бид асуулгын хуудсыг боловсруулахдаа асуултуудын үг хэллэг, утга найруулгын талаар төдийгүй судалгааны бүрэн загварын талаар бодолцох ёстой. Өөрөөр хэлбэл асуулгын хуудсыг судалгааны зорилго, таамаглал, түүвэрлэлтийн хэмжээ, мэдээлэл цуглуулах арга хэлбэр, судалгаанд оролцогч буюу хариулагч зэргээс хамааруулан боловсруулна. Аливаа үзэгдлийн шинж байдал ямар байгааг асуултаар буюу чухамдаа асуулгын хуудсыг ашиглан хэмжиж тодорхойлдог ба энэ нь асуулгын хуудасныхэмжилтийн үүргийн мөн чанарыг илэрхийлдэг. Тухайлбал: жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хэрэглээний түвшинг тодорхойлохын тулд *Та ямар нэгэн жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл хэрэглэдэг үү?* гэсэн асуултыг ашиглана.

Асуулгын хуудсыг боловсруулах үйл явц нь дараахь үе шатыг дамждаг.

Загвар 1. Асуулгын хуудас боловсруулах үйл явц



Асуулгын хуудсанд дараахь **шаардлага** тавигддаг. Үүнд:

1. *Албан баримтын шинж чанартай байна.*

Асуулгын хуудас албан баримтын шинж чанартай байна гэдэг нь хариулагч түүнд хариуцлагатай, итгэлтэй хандаж, үнэн зөв хариулт өгөхүйц байхыг хэлнэ. Асуулгын хуудсанд судалгааны нэр, гүйцэтгэгч, захиалагчийн нэр, судалгаа явуулж буй хугацааг тодорхой бичих бөгөөд, асуулга чухам юунд ашиглагдах, ямар хэрэгцээтэйг товч өгүүлсэн тайлбар буюу судалгаанд идэвхитэй оролцохыг уриалсан өгүүлбэр оруулах нь судалгаанд оролцогчдоос үнэн зөв мэдээлэл авахад ихээхэн нөлөөтэй байдаг. Түүнчлэн асуулгын хуудас албан баримтын шинж чанартай байхад техникийн шаардлага чухлаар тавигдахыг анхаарах хэрэгтэй.

2. *Ёс зүйн баталгаатай байна.*

Асуулгын хуудас нь хариулагчийг хүндэтгэсэн байх ба судалгааны мэдээллийг хүүхдүүдээс цуглуулж байсан ч асуултыг *Оа* гэж тавьдаг. Мөн хариулагчийн нууцыг хадгалах тал дээр судлаачдыг зүгээс баталгаа гарган өгч, судалгаанд оролцсонд талархсан үг, өгүүлбэр заавал оруулна.

3. *Логик дараалалтай байна.*

Асуулгын хуудас логик дэс дараалалтай байна гэдэг нь дараахь шаардлагыг хангасан байхыг хэлнэ. Үүнд:

- Асуулгын хуудсанд адил утгатай асуултыг давхардуулан оруулахгүй байх;
- Асуултыг хариулагч шууд хариулахуйц энгийн асуултаас эхэлж, цаашид өмнөх асуултуудын утга санааг батлах, тэдний сэтгэгдэл, хандлагыг гүнзгий танин мэдэх нарийн төвөгтэй асуулт руу чиглэсэн байдлаар дараалуулах;
- Тодорхой нэг хүнд чиглэгдсэн биш, онцлоогүй асуултаас тухайн хувь хүнд чиглэгдсэн, судалгааны сэдэвтэй шууд холбоотой асуултуудад шилжих байдлаар байрлуулах;
- Асуултыг агуулгаар нь ангилан бүлэглэж, гарчигласан байх;
- Асуулгын хуудсан дахь нэг сэдвийн асуулт дуусаад дараагийн бүлэг асуулт/сэдэв рүү аль болох алгуураар шилжих зэрэг болно.

4. *Хариулагчид бүрэн ойлгомжтой байна.*

Асуулгын хуудсаар цуглуулсан мэдээллийн бодитой эсэх нь хариулагчийн өгсөн хариултаас шууд хамаардаг учраас судлаач асуулгын хуудсыг хариулагчид бүрэн ойлгомжтой байдлаар зохион байгуулах хэрэгтэй болдог. Асуултыг хариулагчид ойлгомжтой байдлаар тавихад, тодруулбал **асуултыг илэрхийлэхэд** дараахь зарчмуудыг мөрдөх хэрэгтэй юм. Үүнд:

<input type="checkbox"/> Хариулагчийн онцлогт тохирсон, ойлгомжтой, зөв үг хэллэг ашиглах Танай сууцанд одоогоор хэдэн орх амьдарч байна вэ?		<input checked="" type="checkbox"/> Танай сууцанд хэдэн гэр бүл амьдарч байна вэ?
---	--	---

<input type="checkbox"/> Асуултыг аль болох бүтэн өгүүлбэрээр тавих Таны боловсрол?		<input checked="" type="checkbox"/> Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү?
--	--	--

<input type="checkbox"/> Асуулганд тодорхойгүй үг хэллэг ашиглахгүй байх Та сүүлийн үед ямар нэгэн орлоготой ажил эрхэлсэн үү?		<input checked="" type="checkbox"/> Та сүүлийн 12 сард ямар нэгэн орлоготой ажил эрхэлсэн үү?
---	--	---

- | | |
|---|---|
| <p>□ Төвчилсон, этгээд, гадаад үг хэллэг, мэргэжлийн нэр томьёо хэрэглэхээс зайлсхийх
Танай <i>гэр бүлийн хэмжээ</i> хэд вэ?</p> | <p>✓ Танай өрхөд одоогоор хэдэн хүн амьдарч байна вэ?</p> |
| <p>□ Нэг асуулгаар нэг л утга санааг илэрхийлэх, өөрөөр хэлбэл, асуулт хоёрдмол санааг агуулаагүй байх
Улаанбаатар хотод шилжин ирснээр таны орлогын түвшин болон эрүүл мэндийн байдалд ямар өөрчлөлт гарсан бэ?</p> | <p>✓ Улаанбаатар хотод шилжин ирснээр таны орлогын түвшинд ямар өөрчлөлт гарсан бэ?
✓ Улаанбаатар хотод шилжин ирснээр таны эрүүл мэндийн байдалд ямар өөрчлөлт гарсан бэ?</p> |
| <p>□ Асуултын хариултууд нь байж болох бүх хувилбарыг багтаасан байх
Таны гэрлэлтийн байдал?</p> <ol style="list-style-type: none"> 1. Огт гэрлээгүй 2. Гэрлэсэн/Хамтран амьдардаг 3. Салсан/Тусгаарласан | <p>✓ Таны гэрлэлтийн байдал?</p> <ol style="list-style-type: none"> 1. Огт гэрлээгүй 2. Гэрлэсэн/Хамтран амьдардаг 3. Салсан/Тусгаарласан 4. <i>Бэлэсэн</i> |
| <p>□ Хариултуудыг ойлгомжтой, уялдаатай байдлаар илэрхийлэх
Таны амьдарч буй сууц тань өөрийн эзэмшлийнх үү?</p> <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн эзэмшлийн 2. Өөрийн эзэмшлийн бус 3. Түрээсний 4. Бусад | <p>✓ Таны амьдарч буй сууц тань өөрийн эзэмшлийнх үү?</p> <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн эзэмшлийн 2. Өөрийн эзэмшлийн бус /Эсвэл тийм, Үгүй/ |
| <p>□ Зөвхөн хариулагчтай холбоотой асуултыг багтаах
Танайхан одоогоор ямар нэгэн ажил эрхэлж байна уу?</p> | <p>✓ Та одоогоор ямар нэгэн ажил эрхэлж байна уу?
✓ Таны эхнэр/нөхөр одоогоор ямар нэгэн ажил эрхэлж байна уу?
✓ Таны хүү/охин одоогоор ямар нэгэн ажил эрхэлж байна уу? ...</p> |
| <p>□ Хэтэрхий нарийвчилсан, их хугацаа зарцуулагдах асуулгаас зайлсхийх
Та дараахь 15 намыг мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар нь эрэмбэлнэ үү.</p> | <p>✓ Та дараахь 5 намыг мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар нь эрэмбэлнэ үү.</p> |
| <p>□ Таамаглаж, тулгасан шинжтэй асуултуудыг тавихгүй байх
Та хэдэн хүүхэдтэй вэ?</p> | <p>✓ Та хүүхэдтэй юу? гэсэн шүүлтүүр асуултанд тийм гэж хариулсан тохиолдолд
✓ Та хэдэн хүүхэдтэй вэ? гэсэн асуултыг асуух</p> |

- Удирдсан, эсвэл ятгаж өдөөсөн асуулгаас зайлсхийх
Та үр хөндөлтийг буруушаадаг биз дээ?
- Та үр хөндөлтийн талаар ямар
бодолтой байдаг вэ?

5. Цомхон байна.

Хэтэрхий урт асуулгын хуудас нь хариулагчийг залхааж, улмаар хариултын чанарт сөргөөр нөлөөлдөг учраас асуулгын хуудсыг хэрэгцээтэй бүх мэдээллийг авахуйц, гэхдээ аль болох цомхон байхаар зохион байгуулах нь зүйтэй. Түүнчлэн асуулгын хуудсан дахь асуулт бүрийн цаана тодорхой хэмжээний зардал байдаг учраас асуулгын хуудсан дахь асуулт бүр “хэрэгцээтэй” байх ёстой. Судалгааны асуулгын хуудасны хэмжээ буюу багтаамж нь судалгааны зорилго, төрөл, түүврийн хэмжээнээс хамааран тодорхойлогддог. Нэлээд өргөн хүрээний зорилго тавьсан судалгааны хувьд асуулгын хуудасны багтаамж их байна. Судалгаанд хамрагдах хүн амын тоо буюу түүвэрлэлтийн хэмжээ хэдийчинээ их байна, асуулгын хуудасны багтаамж төдийчинээ бага шаардлагатай.

3. Асуултын төрлүүд

Асуулгын хуудас нь харилцан уялдаа, логик дараалал бүхий асуултуудын цуваа/бүлгээс тогтдог. Асуулгын хуудсыг хэрхэн боловсруулах нь асуултууд, тэдгээрийн сонголтоос ихээхэн хамаарна. Асуултыг агуулга, хандлага, судалгааны сэдэвтэй холбоотой байдал, хариултын төрөл, сонголт зэргээс нь хамааруулан хэд хэд ангилдаг.

Асуултыг агуулгаас нь хамааруулан *ò°ë°á áàéäëüí* болон *ðáí äëääüí* гэж ангилна. **Төлөв байдлын асуулт** гэдэг нь тухайн үзэгдэл, үйл явцын бодит байдал ямар байгааг илрүүлэн гаргах зорилготой асуултууд юм. Төлөв байдлын асуултуудын мөн чанар нь Хэн?, Юу? Хэзээ?, Хаана?, Хэр зэрэг? Хэр тогтмол? Хэдэн? зэрэг асуултуудад хариулахад чиглэгдэнэ.

Төлөв байдлын асуултын жишээ

- Та одоогоор жирэмслэлтээс хамгаалах ямар арга хэрэглэж байна вэ?
- Та ямар нэгэн тогтмол хэвлэл захиалан уншдаг уу?

Харин судалж байгаа үзэгдлийн талаарх хүмүүсийн үзэл бодол, хандлагыг илрүүлэн гаргах зорилготой асуултуудыг хандлагын асуулт гэнэ. Ирээдүйн төлөв байдлын талаарх асуулт нь хандлагын асуултын нэг төрөл болдог.

Хандлагын асуултын жишээ

- Та гэр бүл төлөвлөлтийг хэнд хамаатай асуудал гэж боддог вэ?
- Та одоогийн амьдарч байгаа газраасаа өөр газарт шилжин суурьших хүсэлтэй байна уу?

Асуултыг **судалгааны сэдэвтэй холбоотой** эсэхээр нь *áí ðääã±*, *ðí*, *ðáíã±*, *ãðääããã±* гэж ангилна. **Анхдагч** асуултууд нь судалгааны сэдэвтэй шууд холбоотой, судалгаанд голлох ач холбогдол бүхий асуултууд юм. Харин судалгааны сэдэвтэй шууд холбоогүй боловч үзэл бодлын тогтвортой байдал, хэрэглэж буй арга хэрэгслийн

найдвартай эсэхийг хянахад ихээхэн үр ашигтай асуултуудыг **хоёрдогч** асуултууд гэнэ. **Гуравдагч** асуултууд гэдэг нь судалгаанд голлох ач холбогдолгүй боловч, хариулагчийг залхаах, сэдвээсээ хазайхгүйгээр мэдээлэл авах, асуулга авах тааламжтай нөхцлийг бүрдүүлэхэд ач холбогдол бүхий асуултууд юм.

Асуултыг **хандлагаар** нь буюу хариулагчид хэрхэн тавьж байгаагаас нь хамааруулан *øббä* болон *øббä äбй* гэж ангилан. **Шууд** асуултууд гэдэг нь хариулагчид шууд хандаж, хүссэн мэдээллээ авах зорилго бүхий асуултууд юм.

Шууд асуултын жишээ

- Та өдөрт хэдэн ширхэг тамхи татдаг вэ?
- Та ямар шапин шүтдэг вэ?

Хариулагчид шууд чиглээгүй боловч шууд бус замаар мэдээлэл цуглуулах боломжтой асуултуудыг **шууд бус** асуулт гэнэ.

Шууд бус асуултын жишээ

- Таны үеийн хүмүүс өдөрт хэдэн ширхэг тамхи татдаг вэ?
- Таны таньдаг хүмүүс ихэвчлэн ямар шапин шүтдэг вэ?

Хариулагчаас шууд асуусан тохиолдолд үнэн зөв мэдээлэл авах магадлал багатай асуултуудыг шууд бус хэлбэрээр тавих нь ихээхэн ач холбогдолтой байдаг.

Тухайн асуултын **хариулт** чухам ямар хэлбэрээр тавигдсан байгаагаас нь хамааруулан хаалттай, нээлттэй, нээлттэй төгсгөлтэй гэж ангилдаг. Хариулт нь тогтоосон сонголт бүхий асуултуудыг **хаалттай асуулт** гэх ба энэ төрлийн асуулт нь хариултын боломжит бүх хувилбарыг багтаасан байдаг. Хаалттай асуултууд нь мэдээлэл боловсруулалтыг хялбар болгодог ач холбогдолтой.

Хаалттай асуулт, хариултын жишээ

- Таны хүйс?
 1. Эрэгтэй
 2. Эмэгтэй
- Та хүүхэдтэй юу?
 1. Тийм
 2. Үгүй

Нээлттэй асуулт гэдэг нь хариулт нь өгөгдөөгүй, өөрөөр хэлбэл хариулагч урьдчилан бэлтгэсэн хариултын кодоос сонгох биш, тохирох хариултын хувилбарыг өгч болохуйц асуултууд болно.

Нээлттэй асуулт, хариултын жишээ

- Та хэдэн настай вэ?
- Танд судалгааны арга зүйн чиглэлээр нэн шаардлагатай байгаа сургалтын 3 чиглэлийг тодорхойлно уу.

1. _____
2. _____
3. _____

Нээлттэй асуулт хариулагчаас илүү дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах боломжтой боловч, мэдээллийг боловсруулахад ихээхэн цаг хугацаа шаардагддаг шинж чанартай байдаг.

Нээлттэй төгсгөлтэй асуулт гэдэг нь судлаач тухайн асуултанд байж болох хариултын хувилбаруудыг санал болгосон урьдчилан бэлтгэсэн боловч, орхигдсон байж болзошгүй хариултын хувилбар нь хариулагчид нээлттэй үлдсэн асуултуудыг хэлнэ.

*Нээлттэй төгсгөлтэй асуулт,
хариултын жишээ*

- Та бэлгийн замын халдварт өвчин ихэвчлэн ямар замаар халдварладаг гэж бодож байна вэ?
 1. Бэлгийн хавьтал
 2. Зүү тариур, эмнэлгийн багаж хэрэгслээр
 3. Ахуйн зам
 4. Бусад/бичих/.....

Асуултыг онгож болох хариултын тооноос хамааруулан *нэг сонголттой, олон сонголттой* гэж ангилна. **Нэг сонголттой асуултууд** гэдэг нь тухайн хариулагчийн зүгээс зөвхөн нэг хариултыг өгөх боломжтой асуултууд юм.

*Нэг сонголттой асуулт, хариултын
жишээ*

- Та гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?
 1. Радио
 2. Телевиз
 3. Сонин хэвлэл
 4. Зурагт хуудас
 5. Эмч/Эрүүл мэндийн ажилтан
 6. Багш
 7. Найз нөхөд/Хамаатан
 8. Бусад/бичих/.....

Судалгааны ихэнх асуултууд нэг сонголттой байх ба нэг сонголттой асуултуудын хариултын кодыг тоогоор тэмдэглэсэн байдаг. Харин хариулагч нэг буюу түүнээс олон хариултын хувилбарыг өгч болохуйцаар тавигдсан асуултуудыг **олон сонголттой асуулт** гэдэг.

Олон сонголттой асуултын жишээ

- Та гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?
 - A. Радио
 - B. Телевиз
 - C. Сонин хэвлэл
 - D. Зурагт хуудас
 - E. Эмч/Эрүүл мэндийн ажилтан
 - F. Багш
 - G. Найз нөхөд/Хамаатан
 - X. Бусад/бичих/.....

4. Асуулгын хуудсыг турших, сайжруулах

Нэгэнт боловсруулагдсан асуулгын хуудсыг сайжруулахад хэрэглэгддэг арга техник нь туршилт байдаг. Туршилт хийх нь дараахь **ач холбогдолтой**. Үүнд:

- Асуултыг хэрхэн тавьбал хариулагчид илүү ойлгомжтой байхыг тодорхойлох;
- Асуултуудад аль болох бүрэн хариулт авах боломжийг илрүүлэх;
- Олон сонголттой асуултуудын хариултыг зөв байрлуулах;
- Асуултуудыг логик дараалалд оруулах;
- Асуултыг бүрэн дуусгахад хэдий хугацаа шаардлагатайг тодорхойлох;
- Ярилцлага авагч хэдэн насны, ямар хүйсийн хүн байвал илүү тохиромжтойг тогтоох;

Туршилт хийгдээгүй “хангалтгүй” асуулгын хуудас нь дараахь шинж чанартай байдаг. Үүнд:

- Орхигдсон болон буруу хариултын хувь өндөр байх;
- Хариулагч тодорхой бус, бүрхэг хариулт өгч байх;
- Зорилгодоо нийцээгүй хэт өргөн хүрээний, эсвэл хязгаарлагдмал мэдээлэл авсан байх;
- Асуултын утга санааг бүрэн тусгаагүйгээс ярилцлагын явцад нэмэлт асуулт тавих болон тайлбар хийх шаардлагатай болох;
- Асуултууд хэт хар ярианы, эсвэл техникийн үг хэллэгээр илэрхийлэгдсэн байна.
- Асуултууд хэт нурусан, эсвэл богино байх;
- Хариулагчийг хэт удирдсан, ятгасан, өдөөсөн байна уу гэдгийг туршиж, сайжруулсан асуулгын хуудасны үр дүнгийн хэм хэмжээ нь судалгааны зорилгод нийцсэн хангалттай, үнэн зөв мэдээллийг цуглуулж чадсан эсэхээр тодорхойлогдоно.

Ашигласан материал:

1. Augustine Okore, Mesim Tumkaya and others, *Introduction to demography*, 1993
2. Б.Жадамба, Ц.Чимэдлхам, *Судалгааны арга зүй*, 2001 он
3. Miriam Comber, *Questionnaire design: Brief introduction*, 2000
4. П.Цэцгээ, А.Солонго, Т.Навч, *Нийгмийн судалгааны арга зүйн гарын авлага*, 2001 он
5. S.Sarantakos, *Social Research*, 1993
6. Section on Survey Research Methods, American Statistical Association, *Designing a Questionnaire*, 1999
7. <http://www.gsr.gov.uk/careers/def.asp>
8. <http://ertr.tamu.edu/showlink.cfm?linkid=509&catid=26>
9. <http://www.testscoring.vt.edu/fraryquest.html>
10. <http://www.cemca.org/books.html>